

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гомбын Халзан	Дугаар	L124
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Халзан
Төрсөн газар	Халзан	Төрсөн он	1928
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Халзан Хатавчийн хийд	Сүм хийдийн дугаар	СБХЛ 037
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 4	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Халзан сумын Хатавчийн хийд

-Хатавчийн хийдийн талаар өөрийн сонссон дуулснаа ярьж өгөхгүй юу?

Зуугийн лам гэдэг лам байгулсан юм гэнэлээ. Оныг нь мартаад байна. Их том хийд байсан 4 дацантай. Зүүний, барууны гээд 2 аймаг болж хурдаг. 500 гаруй ламтай байсан гэсэн байх. 30 хэдэн онд бурхан тахилыг нь байшинтын дивиз гэж байсан. Тэр лүү зөөсөн. Их бурхан шүтээнтэй сүм байсан.

-Таныг өөрийг багадаа бичээч байсан гэсэн?

Би 6, 7 настайдаа нэг ламаар уйгаржин монгол бичиг заалгаж байсан. Сүм 1925 онд байгуулагдсан. Сүм байгуулагдсаны дараахан надаар юм бичүүлдэг байсан. Дарга нь бичиг үсэг мэддэггүй байсан.

-Тэр үед энэ хийдийн маань хэдэн дуганууд нь байв? Хэр олон ламтай байв? Ямар ямар хурлууд хурж байсан байна?

Миний мэдээр, суварганы дэнж дээр Барууны хүрээ гэж байсан том хэрэмтэй тэр хэрэм дотор дөрвөлжин том дуган байсан тэнд л том том хурлуудыг хурдаг байсан. Хойд талд нь хашаандаа 3 сүм байсан. Дүүрэн бурхантай. Сүмийн голд том гэр байдаг байсан. Хашаанд ар талд нь байшинтай Махранз гээд гардаг хаалгатай. Лам нарыг оруулдаг. Цам болохлоор тэр дотор чинь гарч ирдэг. Гэр дуганыхаа үүдэнд хоёр шавар юм байдаг байсан. Одооныхоор манааны шовгорхуу юм байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Хэрэмнийхээ гадаа юм уу?

Дотор дотор. Мөн хэрэмний дотор дуганы үүдэнд нэлээн том талбайтай. Тэндээ цам цамнана их л удаан цамнадаг байсан бараг өдөржин цамнана. Янзын гоё их олон цамтай байсан. Хүрээ дүүрэн л юм гардаг байсан. Цам энэ тэрийг нь зөндөө л үзэж байсан л даа. Баруун урд нь Хашин хаан гэдэг билүү дээ нэг өвгөн суучихсан 2 талд нь 2 хүүхдэрхүү юм суучихсан тэгээд буга цамнана. Сүүлийн үед Тавхай гээд хүн байсан даа. Хотод байж байгаад нас барсан. Тэр өвгөн зайраг буга гэдэгт нь янзын сайхан бүжиглэдэг байсан. Өөр бас нэг буга чойжоо гэдэг гардаг байсан. Хувцас мувцас нь их гоё. Цугласан олныг бүгдийг хүрээнд оруулдаггүй байсан. Тэгээд зайраг буга хүрээнээс гарч цугласан олны дунд орж бүжиглэдэг байсан.

-Цам нь жилдээ хэдэн удаа гардаг байсан бэ?

Нэг л гардаг байсан шиг санаж байна. Урд талдаа Чийга гээд сайхан өндөр зүйл босгочихсон байдаг. Зүүнийх гээд байсан даа. Залгаад баруун дундах гээд дуган хийд байдаг байсан.

-Бүр довцогийн хойно уу?

Тэнд хурал хурдаг байсан. Чухам ямар үед хурдаг байсныг бүү мэд. Тэрний зүүхэн талд голын наад дээр жас гэж байсан. Зүүний болохоор зүүн дундах гээд нэг сүм байсан. Сүмийн шүтээн нь Гомбо гэл үү, Улаан сахиус гэл үү тийм догшин шүтээнтэй тусгай тахидаг сахиусны дуган гэж байсан. Тэрийг тахидаг байсан. Тусгай тахидаг байсан. Тэгээд зүүн талд нь Урагш хойшоо цуварсан 3 сүм байдаг. Тэнд бас хурал хурдаг л юм байсан. Хэдийд хурдаг юм бол тэрийг бол сайн мэдэхгүй. Дунд нь дээшээ гарсан дээрээ жижиг давхартай сүм байсан. Тэрийг Өндөр Майдар гэдэг юм байлээ. Тийм өндөр бурхан байсан. 1930 хэдэн онд сүм хийдүүдийг татан буулгахад Майдар бурханыг гаргаад хүрээг нь түшүүлээд тавьчихсан, бөгсийг нь үхчихсэн байсан. Тэр бурхануудыг нь дивиз рүү зөөгөөд хээ. Одоо энд Агуйт гэж байгаа. Сэнжтэй хад. Тэрний чинь энхүүхэн дээр хүрээний бараа тавьдаг хэдэн лам нарын байшин байсан. Тэр байшингуудад дүүрэн бурхан байдаг байсан даа. Бага байхад тоглоод аав ээждээ загнуулдаг байлаа. За ер нь бурхан бол янзын их байсан даа.

-Та ер нь өөрийн санаж байгаагаар хийдийн бүдүүвч зургийг зураад өгч болох уу?

За ингээд Барууны хүрээ. Энд одоо Махранз гэж жижиг сүмтэй байсан. Энд нэг дуган байсан. Нэг том гэр байсан. Ингээд нэг том сүм. Хурлын дуган. Дээрээ шовгортой. Сүмийн бүх лам л суугаад хурдаг байсан. Цамын талбай, энд хоёр чийга байна. Баруун гэвэл ийм л юм. Баруун дундах сүм. Ийшээ залгаад жас. Хэдэн навсгар байшин. За ингээд гол гарч байгаа юм. Тэгээд лам нарын байшингууд байна. Энд хүрээтэй. Гурван цуварсан сүм. Бурханууд байдаг. Энүүхэн хашаан дотор сахиусны сүм байдаг. Энд жас байна. Тийм л юм байсан.

-Зүүн аймгийн лам нарын байр нь хаагуураа байсан юм бэ?

Зүүн аймгийн лам нарынх нь байр баруун хойд талдаа. Жаахан дов мов байгаа. Тэрүүнийхээ хойхно талаар байгаа.

-Баруун аймгийн лам нарын байр нь хаагуураа байсан бэ?

Барууны лам нарын байр одоо суварга байгаа газар байсан. Уг нь суваргыг яг голд нь ормон дээр барина гэсэн чинь лам нарын байрны суурин дээр барьчихсан байсан. Асуусан хүн нь мартчихсан байсан юм байгаа биз. Бүрүү заагаад өгчихсөн байсан. Энэ юу мэдэхэв гэж бодсон юм байлгүй надаас юм асуугаагүй. Үүсгэн байгуулагдсан талаар сумын түүхийн номон дээр он сартайгаа байгаа. Зуугийн лам гэдэг хүн л байгуулсан юм гэдэг.

-Дөрвөн дацан нь гэж хаанаа байрлах вэ?

Дөрвөн дацантай сүм байсан гэж ярьдаг. Зүүн дундахад нэг дацан хурж байхад тэнд нэг дацан хурж байх жишээтэй. Дацан гэдэг нь хурал явдал. Одоогоор нэг ангирхуу юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Ямар ямар дацан байсан юм бэ?

Тэрийг мэдэхгүй. Дөрвөн дацантай их л том сүм байдаг гэж ярьдаг юм билээ. Дарьгангын тэдэн үеийн мэдээтэй хэдэн сүм байдаг гэсэн. Тэрний нэг л юм гэсэн. 18 сүм байсан гэлүү. Эзний мэдээтэй 18 сүм байсан гэж ярьдаг юм билээ. Тийм л юм гэнэ лээ.

-Тухайн үед Майдар эргэж байсан уу?

Майдар эргэж байсан.

-Хайлан хурж байсан уу?

Хайлан хурна.

-Өөр том хурлуудаас? Онцгой юм болдог байсан уу?

Сор зална. Ер нь шашны ямар л зан үйл явагдах ёстой тэр болгон л явагддаг байсан. Гороо тойроод л мөргөл эргэл хийдэг л байсан.

-Майдар жилдээ хэдэн удаа эргэдэг байсан бэ?

Аа мэдэхгүй. Хоёр бил үү, дөрөв ч бил үү. Тэгш тоотой эргэдэг байсан.

-Тухайн үед номтой том том лам нар, хурал хийдийн тэргүүнийг санаж байна уу та?

Том том лам нар байсан л юм гэсэн. Тэр бүгдийг би сайн мэдэхгүй. Хамба лам нь сүүлийн үед Ба да лам гэж байсан. Нэр нь Балжир да лам. Тэр сүм дээр суудаг хүн биш л дээ. Тэргүүн баян хүн байсан. Ухаандаа жасыг хангахад баян хүн хэрэгтэй байсан юм байлгүй.

-Гэсгүй нь хэн гэдэг хүн байсан бэ?

Гэсгүй гэж сүүлд Равдан гэж хүн байсан. Сайн сайн лам нар байсан л юм гэнэ лээ.

-Гол дуганых нь гэсгүй биз?

Тийм. Тэгээд өөр өөр лам нар байсан л даа.

-Хувилгаан нь ямар учиртай юм бэ?

Хувилгаан нь жинхэнэ шүтдэг 7 хувилсан гэдэг Доголон Билэгт гэдэг хүн байсан гэнэ лээ. Сүүлийнхийг нь би харсан. Сайхн цагаан хар хүн л байсан доголонгүй. Сүм дээр суудаггүй л хүн байсан. Тэрний талаар олон домог л ярьдаг. Доголон Билэгтийн хувилгаан л гэдэг. Ер бол Улаан гавж гээд байсан юм гэнэ лээ. Лам нар бол өөрсдөө Шунлайв багш гэдэг. Шунлайв багш гэдэг нь бүр багаасаа 18-тай гэл үү, Баруун Зууд 3 удаа явсан гэсэн. Хамгийн сүүлд явахдаа шашны эрдмийн ямар дээд байна тэр цолыг нь аваад эрсэн юм гэнэ лээ. Баруун Зууд Дарьгангын жаахан гавж нэртэй их их сайн лам байсан юм гэсэн. Тэр нэг том хийдэд, Ганданд ч юмуу цорж ламаар сууж байгаад удалгүй хөдөө ирж дүү нарынхаа гадаа гэр бариад сууж. Тэр Хатавчийн хийд, Ширээтийн хийд, Мандалын хийд, Бөөрийн хийд, Алтан овоо гээд Дарьганга харъяаны хэсэг сүмийн лам нарын багш нь болж байсан гэдэг. Хатавчийн хийдийн бүх лам нарын мэдэхгүй чадахгүй зүйлийг нь заадаг, номыг нэвтэрхий мэддэг тийм том лам байсан гэдэг. 1920-иод оны хавьцаа нас барсан гэдэг. Манайхны Хатавчийн хийдэд сууж байсан лам нар бүгд л шунлайв багш гэдэг байсан. Манай сүмд 1930 хэдэн онд баригдсан Тавхай, Санжаа гээд өвгөн байсан тэд л сайн мэддэг байсан.

-Энд ном барладаг үйлдвэр байсан уу? Уул овооныхоо сан тахилгыг бичдэг тийм хүн байсан уу?

Тэрийг мэдэхгүй юмаа. Ер нь бол ном урладаг хүмүүс байсан гэсэн. Үйлдвэргүй, өөрсдөө хуваариа ажилладаг, орчуулдаг улсууд байсан гэсэн. Эрэгдэл гээд ном барладаг хүн байсан.

-Хийд тойрсон суварга байсан уу?

Байсан, байсан. Тойрсон олон суврага бол байгаагүй.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Сэнжид суварга байдаг юм уу? Бодь суварга байдаг юм уу? Ямар суварга байсан?

Хашаан дотроо нэг л суварга байсан. За миний мэдэх юм нэг иймэрхүү л юм байна даа.

-Хаагдах нураагдах болсон шалгаан, тухайн үеийн байдал ямаршуу байсан бэ?

1930 хэдэн онд лам нар баригдаад, сүм хийдүүдийг устгаа биз дээ.

-Хаагдах тушаал, нураах тушаалыг ямар хүн өгч байв?

Бүү мэд, тэрийг бол мэдэхгүй. Дээрээсээ бол энэ хийдийг нураах устгах гэсэн юм байхгүй байсан биз. Нам засагт үнэнч болох гэсэн хүмүүс л устгасан байх гэдэг.

-Лам нар баригдаад хийд орон хаагдсан уу? Хийдийг хаачаад лам нарыг барьсан юм болов уу?

Лам нар ч одоо бараг энэ сургаар нь тарсан юм биш үү. Би тэгж ойлгодог юм. Лам нар голдуу гэрээсээ л баригдсан гэж дуулсан, Сүм дээр хурлаа хурж байгаад баригдсан лам бараг байдаггүй юм даа. Баригдсан гэж би дуулаагүй л юм байна.

-Лам нар баригдаад хийд орныг нураагаад барилга байгууламжийг нь юунд ашигласан бэ? Хаашаа зөөсөн? Хэдий үед нураасан?

Зүүн сүмүүдийн барилгыг 1940-өөд оны үед нураасан байх гэж бодож байна. 1950 хэдэн оны үед дугануудад дэлгүүр хоршоо малын эмнэлэг контор түүхий эдийн склад сургууль байрлаж байсан тэрнээс хойш 1950, 60аад оноос зөөгөөд нураагаад эхэлсэн.

-Хийдийн маань ном судар сахиус бурхан тахилын юмнаас үлдсэн барьсан юм айлаар байдаг болов уу?

За даа бараг байхгүй. Шашны зүйл ном судрыг овоогоор тавиад айл амьтнаар үлдсэн юм байдаггүй. Ганц нэг айлуудад Жадамба ч гэх юм уу тийм номнууд байдаг л байсан.

-Ер нь Хатавчийн хийдийн төвд нэрийг юу гэдэг байсан бэ?

Өө мэдэхгүй. Хатавчийн хийд л гэдэг ш тээ. Газар сонгосон нь ямар нэгэн дайралтанд өртөхгүй гэж энэ газрыг сонгосон гэдэг юм байна лээ. Тэгээд сүүлд нь Хонхууз мэтийн 2, 3 хэрцгий дайсангууд энд орж ирсэн. Хатавчийн сүмийг сүйтгэнэ гээд эрээд олоогүй гэж ярьдаг юм билээ.Тийм домогтой юм гэнэ лээ. Сумын түүхийг би бичиж байсан. Сумын түүхэн дээр энэ Хатавчийн хийдийн талаар байгаа.Баяндэлгэрийн Ширээтийн дараа орох байх их л том хийдүүдийн тоонд ордог юм гэнэ лээ.

